

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ НИЙГМИЙН  
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ БИЕЛЭЛТ  
(Орхон аймгийн Эрүүл мэндийн газар)

Хүснэгт 3.6

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газраас төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	320	374	Тайлант хугацаанд нийт 374 сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулснаас 49,5%-ийг ажлын байран дахь сургалт, 14,7%-ийг мэргэшүүлэх сургалт, 7,2%-ийг туршлага солилцох арга хэмжээ эзэлж байгаа бөгөөд давхардсан тоогоор 3496 албан хаагч хамрагдсанаас удирдах албан тушаалтан 7,8%, гүйцэтгэх, туслах, албан тушаалтан 92,2%-ийг эзэлж байна.Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн газарт төрийн албан хаагч 586 ажиллаж байгаагаас сургалтад хамрагдсан нийт албан хаагчдад эзлэх хувь 100% байна. Тайлант хугацаанд сургалт, семинар, зөвлөгөөний тоо өмнөх оноос 7%-аар, хамрагдсан нийт албан хаагчдын тоо 11,3%-иар нэмэгдсэн байна. Доорх материалыг хавсаргав. Үүнд: 1. Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 1-ий өдрийн 13/05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр” болон тус хөтөлбөрийн хүрээнд ЭМГ-аас хийсэн ажлын тайлан /Хавсралт 1/ 2. Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02/16 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын бүлэг, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн 2025 оны төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан /Хавсралт 2/ 3. Эрүүл мэндийн газрын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийг баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт /Хавсралт 3/ <i>Хэрэгжилт 100%</i>
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	130	112	
			Мэргэшүүлэх сургалт	50	55	
			Туршлага солилцох арга хэмжээ	25	27	
			Бусад	80	180	
			1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	1800 /Давхардсан тоогоор/	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	1500	2940	
			Эрэгтэй албан хаагч	300	556	
			Удирдах албан тушаалтан	150	275	
			Гүйцэтгэх, туслах, албан тушаалтан	1650	3221	
1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал, нийт албан хаагчдад эзлэх хувь	100%	100%			
2	Албан хаагчдыг	2.1	Нийт гадаад сургалт,	12	14	Тайлант хугацаанд БНСУ-д болсон Ази, Номхон

	хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.2	семинар зөвлөгөөний тоо			далайн өрхийн эмч нарын чуулганд 8 төвийн 11 эмч оролцож, Энэтхэгийн “Мах Хийлткэйр” группийн хамт 13 өвчтөнд зөвлөгөө өгч, 15 эмчид хавдрын менежментийн сургалт зохион байгуулсан байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс Япон, БНХАУ, Филиппин, Узбекистан, Киргиз, БНСУ зэрэг оронд эх барих, нярайн эмчилгээ, мэс засал, удирдлага, хараа зүй, бөөр, хөнгөвчлөх, мэдрэл зэрэг чиглэлээр 14 эмч олон улсын сургалт, семинарт хамрагдан онол, дадлага хослуулан ур чадвараа дээшлүүлсэн. Австри, БНСУ-д Эрүүл мэндийн газраас 5 мэргэжилтэн туршлага судалсан байна. АНУ-ын Харвардын сургалтын хөтөлбөрт 1 эмчийг тус тус оролцуулж, орон нутгаас 8 сая төгрөгний санхүүжилтийг олгож дэмжлэг үзүүлсэн байна. Нийт 14 удаагийн гадаад сургалт, семинар зөвлөгөөн зохион байгуулагдаж, 30 албан хаагч оролцсоноос удирдах ажилтан 36%, гүйцэтгэх, туслах албан тушаалтан 64%-ийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 16,6%-иар буурсан байна. /Хавсралт 4/  <i>Хэрэгжилт 70%</i>
			Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	61	31	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	57	27	
			Эрэгтэй албан хаагч	4	4	
			Удирдах тушаалтан	5	9	
2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь %	20-оос дээш	9.9			
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1	Албан хаагчдын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ	Орон нутгийн төсвөөс 98.8  Байгууллагын төсөв 95.1	Орон нутгийн төсвөөс 122.5 сая  Улсын төсөв 54.0 сая  Байгууллагаас 80.0 сая	Албан хаагчдын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд 203.5 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 2,4%-аар нэмэгдсэн байна. Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2025-2028/-өөс албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 120 сая төгрөгийг санхүүжүүлсэн. Үүнд: -Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд туршлага солилцох, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх сургалтад 10,0 сая төгрөг -Орон нутагт нэн шаардлагатай тусламжаар эмч, сувилагч нарыг багаар нь гадаад болон дотоодод урт болон богино хугацааны сургалтын дэмжлэгт 66,0 сая төгрөг -Эрүүл мэндийн салбарт нотолгоонд суурилсан судалгаа, шинжилгээ хийх, шинэ төрлийн эмчилгээ,

					<p>технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж 5,0 сая төгрөг</p> <p>-Эрүүл мэндийн салбарын зөвлөлдөх уулзалтын зохион байгуулалтад 10,0 сая төгрөг</p> <p>-Эрүүл мэндийн салбарын тэмдэглэлт өдрүүдийн нөлөөллийн үйл ажиллагаанд 25,0 сая төгрөг</p> <p>-Албан хаагчдын ур чадвар, ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах сургалт, туршлага солилцох уулзалтад 4,0 сая төгрөг</p> <p>Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд:</p> <p>-Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 1 их эмчийн магистрын сургалтын төлбөр болох 1,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>-БОЭТ-ийн 1 эмчийн гадаадад сургалтад 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Дотоод сургалт,туршлага солилцох уулзалт :</p> <p>-Байгууллагын дотоод журмын дагуу мэргэшүүлэх сургалтад 4 албан хаагчид хамрагдаж үндсэн цалинг 100 хувиар 3 сарын хугацаатай нийт 15,0 сая төгрөг олгосон.</p> <p>-Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс Эрдэм шинжилгээний бага хуралд 5,0 сая төгрөг, дотоодын сургалтад 60,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>-ЭМГ-ын албан хаагчдын ЭМЯ, ХСҮТөвд туршлага солилцох уулзалт -10,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>	
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн хувь	15-аас доош	11,2	<p>Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний 60, төрийн захиргааны 6 албан хаагч нийт 66 албан хаагчийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн хүсэлтээр 29 албан хаагч</li> <li>- Эрүүл мэндийн байгууллага хооронд шилжсэн 6</li> <li>- Тэтгэвэрт гарсан 7 албан хаагч</li> <li>- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан 14</li> <li>- Бусад шалтгаанаар гарсан 3</li> <li>- Нас барсан 1 албан хаагч байна.</li> </ul> <p>Шинээр төрийн захиргааны ажилтан 6, төрийн үйлчилгээний ажилтан 38 жирэмсний болон хүүхэд</p>

						асрах чөлөөнөөс орж ирсэн 15, нийт 59 ажилтныг шинэ ажлын байраар хангасан байна. Төрийн албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь 11,2% буюу өмнөх оноос 1,7%-иар буурсан байна. Шилжилт хөдөлгөөний тайланг хавсаргав. /Хавсралт 5/  <i>Хэрэгжилт 100 %</i>
4	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	55.7%	72.9%	Цалин, шагнал урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь 72,9%-ийг эзлэж байна.Тайлант хугацаанд цалин шагнал урамшуулалд Бүсийн оношилгоо эмчилгээний төв 75.7%, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 62,9%-ийг, Эрүүл мэндийн газар нь 74,5%-ыг тус тус зарцуулсан бөгөөд төрийн байгууллагын цалин шагнал урамшуулалд байгууллагын нийт төсвийн дунджаар 71,0%-ийг зарцуулсан байна.  <i>Хэрэгжилт 100%</i>
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол унааны нэмэгдэл /мян.төг/	Хоол, унааны нэмэгдэлд: - ЭМГ 1000төгрөг - БОЭТ 5000 төгрөг Жаргалант сумын эрүүл мэндийн төв 5000 төгрөг	Хоол, унааны нэмэгдэлд: - ЭМГ 11000 төгрөг - БОЭТ 5000 төгрөг - Жаргалант сумын эрүүл мэндийн төв 5000 төгрөг	Эрүүл мэндийн газар нь 2025 оны байдлаар нийт давхардсан тоогоор 352 албан хаагчид унаа хоолны зардлыг өдрийн 11000 төгрөгөөр тооцож, нийт 69.5 сая төгрөг олгосон. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2024 оноос эхлэн ажилтнуудын унаа хоолны зардлыг өдрийн 5000 төгрөгөөр тооцож, 2025 онд 5,753 ажилтанд 528,1 сая төгрөгийг олгосон байна. Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь ажилчдын хоол унааны зардалд өдөрт 5000 төгрөг, тайлант хугацаанд нийт 231 албан хаагчдад 36.6 сая төгрөгийг тус тус олгосон байна.  <i>Хэрэгжилт 100%</i>
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн /Албан хаагчдын сэтгэл ханамж/	80-аас дээш	95.4%	Төрийн албан хаагчийн ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг авахад сэтгэл ханамж 95,4%тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,3%-аар өссөн байна. ЭМГ-ын төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооноос албан хаагчдаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдлийг тодорхойлох” эрсдлийн үнэлгээгээр ёс зүйн зөрчил эсвэл эрсдэлтэй холбоотой үйлдлийг

						<p>огт хийдэггүй гэж хариулсан 64,8%, заримдаа 20.4%, ихэнхдээ 14,8% гэсэн хариултыг илгээсэн байна. Судалгааны дүнг тооцоолоход ёс зүйн эрсдэл 25.1% байна гэж дүгнэсэн байна.</p> <p>Нийт 22 асуумжаар цахим хэлбэрээр судалгааг авсан. Сэтгэл ханамж өссөн үзүүлэлтийг дүгнэхэд төрийн албан хаагчийн цалинд орон нутгийн нэмэгдэл 40%, АЗДТГ-ын санхүүжилтээр “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төслийг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100%</i></p>
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг /жилд/	98%	78.4%	<p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн 157 байгууллагад ажиллаж байгаа 2089 ажилтнаас 1639 буюу 78.4%-ийг ЭМС-ын 340 дүгээр тушаалын дагуу урьдчилан сэргийлэх 10 багцийн үзлэгт хамруулсан нь өмнөх оноос 19,6%-аар буурсан байна.Тус үзлэгээс өөрчлөлттэй илэрсэн 27 ажилтныг амбулаториор онош тодруулан өдрийн эмчилгээнд 100% хамруулсан. Шинээр оношлогдсон, сэдэрлийн үе шатанд байгаа 25 ажилтан хэвтэн эмчлүүлж, 2 ажилтан Хавдар судлалын үндэсний төвд онош тодруулан эмчилгээнд 100% хамрагдсан байна.</p> <p>Цацраг идэвхт тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг Дүрс оношилгооны тасгийн 15 ажилтныг “Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл мэндийн төв”-д урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлж тус бүр 120.0 мянга төгрөг,нийт 1.5 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн.</p> <p>Шүд холбоотой хамтран эрүүл мэндийн салбарын 412 ажилтанг шүдний үзлэгт хамруулан 45 хүнийг эмчилгээнд хамруулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 70%</i></p>
		6.2	Албан хаагчдын хамрагдалтын тоо	1084	1639	<p>Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалын дагуу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын 1639 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр өөрчлөлттэй гарсан ажилчдын 92%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн бөгөөд 8% нь</p>

						үргэлжлүүлэн эмчийн хяналтад эмчлүүлж байна. <i>Хэрэгжилт 100%</i>
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ	Орон нутгийн төсөв 94.7 сая  Байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилт 44.5 сая	Байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилт	Тайлант хугацаанд нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 27.8% нь хамрагдаж, өмнөх оныхоос 3.4 хувиар өссөн бөгөөд нийт 94.7 сая төгрөгийг төрийн албан хаагчдын нийгмийн дэмжлэгт орон нутгийн төсвөөс олгосон нь өмнөх оноос 13.8%-аар нэмэгдсэн байна. Үүнд: - “” хөтөлбөрөөс ажилчдын нийгмийн баталгааг дэмжин 64.7 сая төгрөгийг зарцуулсан бол төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрөөс Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 5 ажилтанд нийт 13.8 сая, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 3 ажилтанд нийт 16.2 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон. <i>Хэрэгжилт 100%</i>
				Хэрэгжилтийн дундаж % (тодорхой үр дүнд хүрсэн)		

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАЛТ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.БЯМБАСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

ТАНИЛЦСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ